

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ 3 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2016 оны хоёрдугаар сарын 25-ны 11 цаг 18 минутад эхэлж, 13 цаг 10 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн даргын өрөөнд болж, нийт 1 цаг 52 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Сайнцагаан сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтын дүнгийн тухай тухай	Сайнцагаан сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан Дэлгэрмаа шүүхэд хандан, хянан шийдвэрлэх шатандаа явж байгаа тул нэр дэвшүүлэх асуудлыг шүүхийн эцсийн шийдвэр гартал түр хойшлуулахаар болов.
2	Төрийн захиргааны байгууллагын ёс зүйн хороодын тайлан мэдээ ирүүлсэн дүнгийн тухай	Төрийн захиргааны байгууллагуудын Ёс зүйн хороодын үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор зөвлөмж хүргүүлэх, тайланг хугацаандаа ирүүлэх талаар сум байгууллага хариуцсан гишүүдэд нь даалгав.
3	Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байгаад ажлаас халагдсантай холбогдолтой гомдлыг хянан шийдвэрлэсэн дүнгийн тухай	Говь-Угтаал сумын Засаг даргын “Ажлаас халах тухай” 2015 оны Б/24 тоот захирамжид дурьдсан Төрийн албаны тухай хуулийн 25,1,1-ийг үндэслэсэн, ёс зүйн доголдол удаа дараа гаргасан нь баримтаар нотлогдохгүй байгаа болон урьд авагдсан сахилгын шийтгэлийг давхардуулан хэрэглэсэн тухай Маргаан хянан шийдвэрлэх комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэж, “Ажлаас халах тухай” 2015 оны Б/24 тоот захирамжийг хүчингүй болгож, шийдвэр гаргахдаа хууль, тогтоомжид нийцүүлэн гаргаж байхыг Говь-Угтаал сумын Засаг дарга /Ч.Энхцэцэг/-т үүрэг болгосон тогтоол гаргаж, уг тогтоол, ёс зүйн хорооны дүгнэлтийг холбогдох байгууллага, хүмүүст хүргүүлэхээр шийдвэрлэв.
4	Луус сумын иргэн Алтанчимэгийн Ёс зүйн хороонд ирүүлсэн өргөдлийн талаарх дүгнэлтийн тухай	Луус сумын иргэн Алтанчимэгийн Ёс зүйн хороонд ирүүлсэн өргөдлийн талаарх дүгнэлтийг иргэн Алтанчимэгт хүргүүлэхээр шийдвэрлэв.
5	Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг шинэчлэн батлах тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйл, салбар зөвлөлийн ажиллах журмын 2-р зүйлд заасан холбогдох эрх, үүргийг сум байгууллагад хэрэгжүүлэх зорилгоор салбар зөвлөлийн гишүүдэд сум, байгууллагыг хариуцуулах хуваарийг баталсан тогтоол гаргахаар болов.
6	Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох журам батлах тухай	Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.9 дэх заалт, 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт, 7 дугаар зүйлийг тус тус үндэслэн “Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн гишүүдийн ажлын үр дүнг үнэлж, урамшуулал олгох журам”-ын төслийг хэлэлцээд батлахаар шийдвэрлэв.
6	Аймгийн “Шилдэг менежер” шалгаруулах	Сумын Засаг даргатай байгуулсан 2015 оны үр дүнгийн гэрээгээ амжилттай биелүүлж, аймгийн шилдэг менежерийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан Баянжаргалан сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Батпүрэв овогтой Цэцэгжаргал, Гурвансайхан сумын сургуулийн захирал Жамъянсүрэн овогтой Цэцэгдэлгэр, Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын дарга Баатар овогтой Хорлоо, Дэрэн сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Чулуунбаатар овогтой Баярмаа нарыг 2015 оны аймгийн “Шилдэг менежер”-ээр шалгаруулж шагнахаар шийдвэрлэв.